



# Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөлд олгох ААНОАТ-ын хөнгөлөлт



ААНОАТ-ын тухай хуульд 2024 оны 08 дугаар сарын 30-ний өдөр орсон нэмэлт, өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсан санхүүжилтийн дүнгээр ААНОАТ-ыг хөнгөлөлт олгох зохицуулалт нэвтэрсэн билээ. Уг хөнгөлөлтийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийг Монголын Татварын Албанаас 2025 оны 09 дүгээр сарын 01 гаргасан ба энэхүү татварын мэдээллээр бид та бүхэнд уг татварын хөнгөлөлтийг эдлэхэд анхаарах зүйлсийг хураангуйлан хүргэж байна.

Татварын хөнгөлөлт эдлэхэд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагуудыг хангаж ажиллах, хөнгөлөлтийг татварын тайлан, тооцонд зохистой тайлагнаж, хянуулах үйл ажиллагаанд бид мэргэжлийн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах боломжтой.

## 1. ААНОАТ-ын хөнгөлөлтөд тавигдах ерөнхий нөхцлүүд:

- Тухайн татварын жилийн ААНОАТ-ын нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлогын **1%**-аас хэтрэхгүй байх;
- Уг татварын хөнгөлөлт нь **2035.1.1**-нийг хүртэл нь үйлчилнэ;
- Татварын хөнгөлөлтийг дараагийн татварын жилд шилжүүлэн тооцохгүй;
- Хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл нь татварын төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй байх;
- Татварын хөнгөлөлтийг татвараас зайлсхийх зорилгоор хэрэглэсэн нь тогтоосон тохиолдолд хөнгөлөлтийг эдлүүлэхгүй;
- Санхүүгийн дэмжлэг, хандивыг харилцан хамааралтгүй этгээдэд олгосон байх;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй тохиолдолд хөнгөлөлтийг эдлүүлэхгүй;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь ААНОАТ-ын хуульд заасан хасагдах зардлын ерөнхий шаардлагуудыг хангасах байх;
- Салбарын бодлогод нийцүүлэн хариуцсан яамнаас гаргасан хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартад нийцсэн байх (*Дараагийн хуудаснаас уг хөнгөлөлттэй холбоотой яамдаас баталсан шаардлага, стандартын хураангуйг харна уу*).

## 2. Төсөл, үйл ажиллагаанд тавигдах тусгай шаардлагууд:

|                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
|-----------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Хөрөнгө оруулалтын төсөл</b>   | <ul style="list-style-type: none"><li>✓ Өөрийн, эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох хөрөнгөнд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;</li><li>✓ Татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;</li><li>✓ Татвар төлөгчийн бизнесийн төлөвлөгөөнд тусгаж, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;</li><li>✓ Өөр хуулийн этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх.</li><li>✓ Салбарын асуудал эрхэлсэн яамдын баталсан стандарт шаардлагын бусад нөхцөлийг хангасан байх.</li></ul> |
| <b>Санхүүгийн дэмжлэг, хандив</b> | <ul style="list-style-type: none"><li>✓ Хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет хөрөнгө байх;</li><li>✓ Санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив өгсөн талтай харилцан хамааралгүй байх;</li><li>✓ Санхүүгийн дэмжлэг, хандивын тусгай зориулалтад нийцүүлэн гэрээ байгуулж, нотариатаар гэрчлүүлсэн байх;</li><li>✓ Санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь тухайн тайлант хугацаанд хамрагдсан, дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх;</li><li>✓ Салбарын асуудал эрхэлсэн яамдын баталсан стандарт шаардлагын бусад нөхцөлийг хангасан байх.</li></ul>                                                                                      |

### 3. Татварын хөнгөлөлт эдлүүлэх нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх төсөл, хөтөлбөрийн чиглэл, тавигдах шаардлага

| №                                                                                       | Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх төсөл, хөтөлбөрийн ангилал                                                                                                                                                                                                                                                                                                                    | Хариуцах яам             | Үйл ажиллагааны ерөнхий чиглэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | Баталсан огноо | Тушаалын дугаар |
|-----------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-----------------|
| 1<br>  | Ой, амьтан, ус зэрэг байгалийн баялаг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, зохистой ашиглах, нөхөн сэргээх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, цөлжилтийг сааруулах                                                                                                                                                                                                                | ➤ БОУАӨЯ.<br>➤ ХББОСЯ    | ✓ Агаарын бохирдлыг бууруулах;<br>✓ Ойжуулалт, ногоон байгууламж, тохижуулах;<br>✓ Хөрс хамгаалах, цөлжилтийг сааруулах<br>✓ Хог хаягдлыг бууруулах;<br>✓ Биологийн төрөл зүйлийн хамгаалах.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 2025.02.24     | A/93, 105       |
| 2<br>   | Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн асрамжийн үйлчилгээ, тэдгээрийн эрхийг хангах, хамгаалах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгат орчин бүрдүүлэх, хүүхдийн тоглоомын талбай, зуслан, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах                                                                                                                    | ➤ ГБХНХЯ                 | ✓ Төрөлжсөн асрамжийн газар шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх<br>✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохируулгат орчинг бүрдүүлэх, засварлах<br>✓ Хүүхдийн зуслан, төв шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх<br>✓ Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн шинээр барих, сэргээн засварлах, тохижилт, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх<br>✓ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн ААН-ийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж | 2024.12.12     | A/67            |
| 3<br> | Соёлын өвийг хамгаалах, сэргээх, музей, номын сангийн үйл ажиллагаа болон хөгжим, кино, гар урлал, тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах                                                                                                                                                                 | ➤ ССАЖЗЯ<br>➤ ХББОСЯ     | ✓ Соёлын өвийг хамгаалах;<br>✓ Музейн үйл ажиллагааг дэмжих;<br>✓ Номын сангийн үйл ажиллагааг дэмжих;<br>✓ Хөгжмийн урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх;<br>✓ Кино урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх;<br>✓ Гар урлалын бүтээл туурвих, тоглох, түгээх;<br>✓ Тайзны урлагийн бүтээл туурвих, тоглох, түгээх;<br>✓ Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор барьж байгуулах, ашиглах.                                                                                                                                                                                                    | 2025.05.07     | A/175           |
| 4<br> | Нийтийн эзэмшлийн зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, ашиглах, хамгаалах, тохижуулах, цэцэрлэгжүүлэх, нийтийн тээврийн хөгжлийг дэмжих;                                                                                                                                                                                                                               | ➤ ХББОСЯ<br>➤ ЗТЯ        | ✓ Авто зам барих, тохижуулах (Унадаг дугуйн зам барих, хурд саруулагч барих, авто замын тэмдэг барих)<br>✓ Нийтийн үйлчилгээний цахилгаан тээврийн хэрэгсэл угсрах<br>✓ Төмөр зам ба түүний гүүр хоолой тавих<br>✓ Нийтийн эзэмшлийн талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах, тохижуулах;                                                                                                                                                                                                                                                                                                    | 2025.05.12     | 105, A/272      |
| 5<br> | Спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг                                                                              | ➤ ССАЖЗЯ                 | ✓ Спортын барилга байгууламж барьж байгуулах<br>✓ Олимп, оюуны спортын төрлийн тэмцээн зохион байгуулах<br>✓ Монголын үндэсний олимпын хороо, Монголын үндэсний паралимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг                                                                                                                                                                                                                                                                             | 2025.05.07     | A/175           |
| 6<br> | Давагдашгүй хүчин зүйл болон түүнтэй адилтгах бусад гамшгийн улмаас хохирол барагдуулах                                                                                                                                                                                                                                                                                            | ➤ МУ-ын Шадар сайд "ОБГ" | ✓ Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламж<br>✓ Дэд бүтцийг сэргээн засварлах, шинээр төлөвлөх, дахин барих                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | 2025.02.05     | 18              |
| 7<br> | Монгол Улсын Засгийн газраас зарласан тэргүүлэх чиглэлээр гадаадын их, дээд сургууль, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгосон сургалтын төлбөрийн тэтгэлэг<br>Их, дээд сургууль, шинжлэх ухааны академид судалгаа, шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг | ➤ БЯ                     | ✓ Сургалтын байгууллагын орчныг дэмжих бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа<br>✓ Санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, хандив, тусламж                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 2025.05.02     | A/189           |

### 3. Татварын хөнгөлөлт эдлүүлэх нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх төсөл, хөтөлбөрийн чиглэл, тавигдах шаардлага

| №  | Нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдэх төсөл, хөтөлбөрийн ангилал                                                                                                                                        | Хариуцах яам | Үйл ажиллагааны ерөнхий чиглэл                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Баталсан огноо | Тушаалын дугаар |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-----------------|
| 8  |  Төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа                                  | БЯ<br>ЭМЯ    | <ul style="list-style-type: none"> <li>✓ Хүний хөгжил, сургалтыг дэмжих үйл ажиллагаа</li> <li>✓ Эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламж барих, өргөтгөх, засварлах, тохижуулах</li> <li>✓ Сургалтын байгууллагын орчныг дэмжих бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаа</li> <li>✓ Эмнэлгийн хэрэгслээр хангах</li> <li>✓ Эмнэлгийн тоног төхөөрөмжөөр хангах</li> <li>✓ Нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг дэмжих</li> <li>✓ Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээг сайжруулах</li> <li>✓ Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг сайжруулах</li> </ul> | 2025.05.07     | A/189           |
| 9  |  Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа.                                                                          | ЭЗХЯ         | <ul style="list-style-type: none"> <li>✓ Санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 2025.06.13     | A/76            |
| 10 |  Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдийн хуульд заасан үйл ажиллагаа. | ЦХИХЯ        | <ul style="list-style-type: none"> <li>✓ Харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах</li> <li>✓ Радио, телевизийн үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх</li> <li>✓ Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих Виртуал бүсэд бүртгэгдсэн хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт</li> </ul>                                                                                     | 2025.05.09     | A/79            |

### 4. Татварын хөнгөлөлтийг тайлагнах

Татварын хөнгөлөлтийг ААНОАТ-ын ТТ-02 тайланд тайлагнах байдлаар эдлэх ба үүнд дараах шаардлагууд тавигдана:

- Хавсралт мэдээ, хөнгөлөлтийн тодруулга мэдээг зөв бөглөх;
- Гэрээ, төлбөрийн баримт болон бусад шаардлагатай бичиг баримтуудыг хавсаргах;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг олгосон тал хасагдахгүй зардлаар, авсан тал татвар ногдох орлогоор тайлагнах ба дараах хавсралтуудыг мөн бэлтгэж илгээнэ:

#### Санхүүжилтийг олгосон ААН

- **ТМ-1а:** Элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлын тодруулга мэдээ
- **ХМ-02/8/:** Албан татварын хөнгөлөлтийн тооцоолол

#### Санхүүжилт хүлээн авсан ААН

- **ТМ-1б:** Хөрөнгө оруулалт хүлээн авагчийн үндсэн хөрөнгийн тодруулга мэдээ
- **ТМ-1в:** Санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авагчийн зарцуулалтын тодруулга мэдээ

- Төсөл, хөтөлбөрт хяналт тавих салбарын яамдыг хавсралт мэдээнд зөв сонгож тайланг илгээх.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд олгосон төсөл (НХХОТ)-ийн ААНОАТ хөнгөлөлтийг бусад ААНОАТ-ын хөнгөлөлтүүдтэй давхаруулан эдлүүлнэ. Ингэхдээ нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулсан дүнгээс НХХОТ хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүнд бусад албан татварын хөнгөлөлтийг тооцно.
- Хялбаршуулсан горимын дагуу албан татвар төлж, тайлагнадаг ААН хувьд НХХОТ-ийн хөнгөлөлтийг эдлэхгүй.



#### 4. Татварын хөнгөлөлтийг тайлагнах

Энэ татварын мэдээллийн 3 дахь хэсэгт дурьдчилсан нийгмийн хариуцлагын хүрээнд Албан татварын хөнгөлөлт эдлэх албан татвар төлөгч нь ААНОАТ-ын жилийн (ТТ-02) тайланг, бусад шаардлагатай бичиг баримтыг хавсарган татварын алба руу 2-р сарын 10-ны дотор илгээнэ.


Зарим яамд хувьд тайланг хүргүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааг өөрсдийн баталсан шаардлагын хүрээнд зохион байгуулах хугацааг дараах байдлаар тусгайлан заасан байна.

| Тайлангийн хугацаа | Тайланг хүлээн авах             | Тайланг яаманд хүргүүлэх        | Тайланг баталгаажуулах          |
|--------------------|---------------------------------|---------------------------------|---------------------------------|
| 1-р улирал         | 4-р сарын 20-ны дотор           | 5-р сарын 10-ны дотор           | 5-р сарын 31-ны дотор           |
| 2-р улирал         | 7-р сарын 20-ны дотор           | 8-р сарын 10-ны дотор           | 8-р сарын 31-ны дотор           |
| 3-р улирал         | 10-р сарын 20-ны дотор          | 11-р сарын 10-ны дотор          | 11-р сарын 31-ны дотор          |
| 4-р улирал         | Дараа оны 2-р сарын 20-ны дотор | Дараа оны 3-р сарын 10-ны дотор | Дараа оны 3-р сарын 31-ны дотор |

#### ? Анхаарах зүйл

Татварын алба хөнгөлөлт эдлэхээр хүргүүлсэн татвар төлөгчийн жилийн эцсийн тайланг хянаж шаардлага хангаагүй тайланг татвар төлөгч рүү буцаах ба тухайн буцаагдсан тайланг залруулах хугацаа дуусгавар болсон тохиолдолд нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх хөнгөлөлт эдлүүлэхгүйг анхаарна уу.

#### 5. Татварын хөнгөлөлтийн тайлагналыг хянах, хүлээн авах үйл явц





## Товчилсон үгсийн тайлбар

| Товчилсон үг | Тайлбар                                         |
|--------------|-------------------------------------------------|
| ААНОАТ       | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар           |
| ААН          | Аж ахуйн нэгж                                   |
| БОУАӨЯ       | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам    |
| ХББОСЯ       | Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам |
| ГБХНХЯ       | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам      |
| ССАЖЗЯ       | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам    |
| ЗТЯ          | Зам тээврийн яам                                |
| ЭМЯ          | Эрүүл мэндийн яам                               |
| ЭЗХЯ         | Эдийн засаг, хөгжлийн яам                       |
| ЦХИХЯ        | Цахим хөгжил иновац, харилцаа холбооны яам      |

## Холбоо барих мэдээлэл:



**Серги Кобахидзе**  
Партнер  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
[sergi.kobakhidze@pwc.com](mailto:sergi.kobakhidze@pwc.com)



**Цэндмаа Чойжамц**  
Захирал  
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
[tsendmaa.choijamts@pwc.com](mailto:tsendmaa.choijamts@pwc.com)



**Энхзул Жамбал**  
Ахлах Менежер  
Татварын зөвлөх үйлчилгээ  
[enkhzul.jambal@pwc.com](mailto:enkhzul.jambal@pwc.com)



**Энхсанаа Эрдэнэ-Очир**  
Ахлах Менежер  
Татварын зөвлөх үйлчилгээ  
[enkhsanaa.erdene-ochir@pwc.com](mailto:enkhsanaa.erdene-ochir@pwc.com)

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлагыг үүрэхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайвотэрхаусКүүперс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.